



ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО,
ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН
ТОГТООЛ

2018 оны 04 сарын 24 өдөр

Дугаар 148

Улаанбаатар хот

Үндсэн хөрөнгө акталж,
данснаас хасах зөвшөөрөл олгох тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 8, 31 дүгээр зүйлийн 1, 3 дахь хэсэг, "Төрийн болон орон нутгийн өмчийн эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх, журам"-ын 6.2.1, 6.2.5, 6.4.3, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2016 оны 128 дугаар тогтоолын 5.4 дэх дахь заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1.Шүүхийн Ерөнхий зөвлөлийн харьяа Баянхонгор аймаг дахь Шүүхийн Тамгын газрын үндсэн хөрөнгөд бүртгэлтэй, Мэргэжлийн хяналтын газрын улсын байцаагчийн 2014 оны 05-07-018/373, 2018 оны 05-07-018/17 дугаар дүгнэлтээр цаашид зориулалтын дагуу ашиглах боломжгүй болсон нь тогтоогдсон, элэгдлээрээ анхны өртгөө нөхсөн нийт 11,670,000.00 (арван нэгэн сая зургаан зуун далан мянган) төгрөгийн балансын үнэ бүхий хавсралтад заасан автомашиныг акталж, данснаас хасахыг зөвшөөрсүгэй.

2.Баянхонгор аймгийн Шүүхийн Тамгын газрын дарга М.Майжаргалд дор дурдсан арга хэмжээ авч ажиллахыг даалгасугай:

2.1.Байгууллагын өмч хамгаалах Байнгын зөвлөлийн хяналт дор хавсралтад заасан автомашиныг сэлбэг, материалаар худалдах, данснаас хасах ажлыг холбогдох хууль тогтоомжийн дагуу зохион байгуулах;

2.2.Хөрөнгийн хөдлөлийг зохих хууль тогтоомж, журмын дагуу нягтлан бодох бүртгэл, тайланд тусган, "Төрийн болон орон нутгийн өмчийн удирдлагыг мэдээлэлжүүлэх систем"-д бүртгэх;

2.3.Энэ тогтоолын биелэлтийг 2018 оны 2 дугаар улиралд багтаан Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газарт ирүүлэх.

3.Энэхүү тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн бүртгэл, хяналтын хэлтэс (Ц.Түвшинзаяа)-т үүрэг болгосугай.


ДАРГА

ЗАХИРГАА, ХУУЛЬ ЗҮЙН ХЭЛТСИЙН
ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ
ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ

Ц.НЯМ-ОСОР

Э.ЭРДЭНЭХИШИГ

0001707



Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын
2018 оны 04 дүгээр сарын 04-ны өдрийн
198 дүгээр тогтоолын хэсэгт

БАЯНХОНГОР АЙМАГ ДАХЬ ШҮҮХИЙН ТАМГЫН ГАЗРЫН БАЛАНСАД БҮРТГЭЛТЭЙ АНГАРЖ,
ДАНСНААС ХАСЧ, СЭЛБЭГЭЭР ХУДАЛДАХ АВТОМАШИН

Д/д	Хөрөнгийн нэр	Ашиглалтанд орсон огноо	Хэмжих нэгж	Тоо ширхэг	Балансын үнэ	(төгрөг)			Сэлбэгээр худалдснаас олох орлогын хэмжээ /доод үнэ/
						Хуримтлагдсан элэгдэл	Үлдэгдэл өртөг		
1	Суудлын автомашин, Исузу Бигорн, 00-09 БНА, арал 7272611	1996	ш	1	11,670,000.00	11,670,000.00	-	300,000.00	
Нийт дүн					11,670,000.00	11,670,000.00	-	300,000.00	
					(арван нэгэн сая зургаан зуун далан мянган)	(арван нэгэн сая зургаан зуун далан мянган)	-	(Гурван зуун мянга)	